

ӨМНӨХ ҮГ

“Иргэн баян бол улс баян” хэмээх үг буй. Үүний цаана иргэн бүр эрх үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйдаа эзэн болж чадвал улс орны хөгжил сайн сайхан байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс санхүүгийн хувьд чадамжтай байх нь илүү чухаг. Төр засаг дангаараа ажиллаад энэ зорилгыг биелүүлэх боломжгүй, гагцхүү үүнд иргэн бүрийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачлага, оролцоо хэрэгтэй юм.

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 онд батлуулаад байна. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд хувь хүн Та өөрийн санхүүгээ зөв удирдан жолоодох, тухайлбал, хувь хүний санхүүгийн талаарх үндсэн

ойлголт, тодорхойлолтууд, орлого, зарлагаа тооцоолох, хянах, хуримтлал, хадгаламжтай болох, хөрөнгө мөнгөө зарцуулахтай холбогдон гарч болох аливаа эрсдэлт байдлаас сэргийлэх, хамгаалах, эдийн засаг, санхүүтэй холбоотой зөв, оновчтой шийдвэр гаргах зэрэг өөрийн өдөр тутмын болоод ирээдүйн эдийн засгийн амьдралд нэн шаардлагатай, мэдвэл зохих хувь хүний санхүүгийн мэдлэг, ур чадварыг эзэмших юм.

Бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахыг тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ бүрэн хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахтай холбоотой хувь хүний санхүүгийн төлөвлөлт танд маш чухал. Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц бололцоог ашиглах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах, мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргах, сонголт хийхдээ хэрэглэх зөв мэдлэг, хандлага, ур чадвар, зан үйл, дадал зуршлыг энэ гарын авлагаас олж авна гэдэгт бид найдаж байна.

МОНГОЛБАНК
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

1. ТАТВАРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

www.sankhuugiinbolovsrol.mn

“Төр оршихуй дор татвар буй. Татвар буй дор төр оршмуй”

Чингис хаан

Таны хөдөлмөрлөж олсон орлогоосоо төлсөн татвар ямар ач тустай вэ?

Татвар нь төрийн оршин тогтнох үндэс болдог. Өөрөөр хэлбэл төр үйл ажиллагаа явуулах, улс орныг батлан хамгаалах, эдийн засаг, нийгмийн хэрэгцээг хангах, хөгжүүлэхэд шаардлагатай мөнгийг татвараар бүрдүүлнэ. Таны төлсөн татвар зөвхөн улс эх орны хөгжлөөр зогсохгүй танд, таны үр хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, тав тухтай амьдралд чухал ач холбогдолтой. Тухайлбал:

1. Үйлдвэр, сургууль, цэцэрлэг барих, зам тавих гэх мэт төсвөөс зарцуулж байгаа мөнгийг татвараар бүрдүүлдэг.
2. Таны үр хүүхдийг үнэ төлбөргүй боловсрол эзэмших, сурч хүмүүжихэд татварын мөнгөний тодорхой хэсгийг зарцуулдаг.

3. Орлого олох боломжгүй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд зориулах нийгмийн халамжийн үйлчилгээний зардлыг мөн л татварын мөнгөнөөс зарцуулдаг.

Энэ мэтчилэн татварын ач тусыг дурдаад байвал багагүй. Иймээс хүн бүр татвараа үнэнч шударгаар төлж хэвших нь улс орны хөгжил, түүгээр дамжаад иргэдийн сайн сайхан амьдралд хэрэгтэй.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Монгол Улсын иргэний үндсэн үүргийн нэг нь хуулиар ногдуулсан албан татвар төлөх явдал юм.

Татвар:

Хувь хүн, байгууллагын олсон орлого, ашиг, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнээс хуулинд заасан хувь хэмжээгээр авч, улсын төсөвт оруулж байгаа мөнгийг хэлнэ.

Улсын төсөв:

Засгийн газрын мэдэлд төвлөрч, улс орны нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд зарцуулдаг мөнгөн хөрөнгийн сан юм.

Татварыг шууд болон шууд бус татвар гэж ангилна.

Шууд татвар:

Татвар төлөгчийн орлого, ашгийн хэмжээ, эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан хэмжээг нь тогтоож, хураан авч байгаа татварыг хэлнэ.

Жишээ нь: Та сард 500 000 төгрөгийн цалин авдаг бол таны цалингийн орлогоос 10%-иар тооцож, хувь хүний орлогын албан татварыг хураан авдаг.

Шууд бус татвар:

Татвар төлөгчийн үйл ажиллагааны үр дүнгээс хамааралгүйгээр тодорхой нэрийн бараа, үйлчилгээнд ногдуулж байгаа татвар юм.

Шууд бус татварыг татвар төлөгч хэдий хэмжээний ашиг, орлого олсон, ямар хөрөнгө эзэмшиж байгаагаас үл хамаарч бараа, үйлчилгээний үнээр дамжуулан хураан авч байгаа татвар юм. Энэ татварыг бараа, үйлчилгээний үнэд шингээсэн байдаг. Иймээс шууд бус татвар ногдуулсан бараа, үйлчилгээг худалдан авсан хэрэглэгч тухайн татварыг төлнө. Жишээ нь: Таны худалдан авсан талхны үнэд нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн байдаг. Та талх худалдан авснаар үнээр дамжуулан уг татварыг төлдөг.

Татварын хуулинд заасан хувиар тооцож авахаас гадна хэдий хэмжээний орлого олсныг нь тэр бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээний орлого, зарим хөрөнгөд тогтмол мөнгөн дүнгээр татвар ногдуулдаг. Тухайлбал, Улаанбаатар хотод оршин суудаг, цаг засварлах үйлчилгээ эрхэлдэг иргэн сар бүр 3000 төгрөгийн¹ тогтмол татвар төлөхөөр хуульд заасан байдаг.


¹ Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль, 2001 он. 5.1.2 дахь заалт.

Тогтмол татвар:

Татвар ногдуулах зүйлд тогтмол мөнгөн дүнгээр ногдуулж буй татварыг хэлнэ.

Хувь хүний төлдөг татварыг үндсэн дөрвөн төрөлд хувааж болно.

Зураг 1. Олон улсын жишгээр хувь хүний төлдөг татварын төрөл



2. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР, ТҮҮНИЙГ ТООЦООЛОХ НЬ

www.sankhuuginbolovsrol.mn

Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь хувь хүний хөдөлмөр эрхлэх, хөрөнгө борлуулах зэргээр олсон бүх орлогод ногдох албан татвар юм. Уг татварын харилцааг “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-иар зохицуулна. Хувь хүний орлогын албан татвар төлөгч нь тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, орлого олоогүй ч хуульд заасан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн байна.

Татвар төлөгч:

Өөрийн олсон орлого, эзэмшиж байгаа хөрөнгөдөө ногдох татварыг төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна.

“Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-д зааснаар хувь хүн олсон дараах орлогоосоо татвар төлнө. Өөрөөр хэлбэл, хувь хүний олсон орлогыг дараах байдлаар ангилдаг. Зураг 2-ыг харна уу.

Зураг 2. ХХОАТ ногдох орлого



Хувь хүний орлогын хамгийн гол эх үүсвэр нь цалингийн буюу хөдөлмөрийн хөлсний орлого байдаг. Иймээс цалингаасаа хичнээн хэмжээний

татвар төлж байгаагаа тооцоолж сурах нь орлогоо төлөвлөх, цалинг зөв бодсон эсэхийг хянахад хэрэгтэй.

ТЭМҮҮЛЭНД ТОХИОЛДСОН СУРГАМЖТАЙ ЯВДАЛ



Тэмүүлэн дээд сургууль төгссөн даруйдаа нэгэн байгууллагад ажилд оржээ. Хөдөлмөрийн гэрээнд сарын 500,000 төгрөгийн цалин олгоно гэж бичсэн байв. Ажилд орсныхоо маргааш орой эхнэр Солонгын хамт цалингаа юунд зарцуулах тухайгаа ярилцаж, төсөв зохиов. Үүнд: Анхны цалингаасаа гэр бүлийнхэндээ бэлэг авч өгөх, хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг төлөх, ажилдаа ирж очих унааны зардал, өдрийн хоолны мөнгө гэх мэт шаардлагатай зардлуудаа төлөвлөж, 500,000 төгрөгийн орлогоо бүгдийг хуваарилжээ. Сарын эхний цалингаас төлөвлөсөн зүйлдээ мөнгөө зарцуулж эхлэв. Хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг сүүлийн цалин дээрээс өгөхөөр тооцсон байв.

Гэтэл сарын сүүлийн цалин буухад Тэмүүлэн тооцоолж байснаас 88,000 төгрөгийн дутуу цалин авчээ. Хүүгийнхээ цэцэрлэгийн мөнгийг яаж төлөх вэ? гэдэг том асуудал үүсэв.

УЧИР ЮУНД БАЙНА ВЭ???

Тэмүүлэн цалингаас татвар суутган авдгийг мэддэггүй байжээ.

Хувь хүний олгохоор тооцсон цалингаас байгууллага нь нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл (хуулийн дагуу хувь хүний өөрийн төлөх 10%)-ийг суутган авч, нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлнэ. Түүний дараа ХХОАТ-ыг 10%-иар тооцно. Үүнээс ХХОАТ-ын хөнгөлөлт болох сарын 7000 (84000₮/12 сар) төгрөгийг хасаж төлөх татварын дүнг гаргана. Учир нь “Хувь

хүний орлогын албан татварын хууль”-ийн 24.1-д заасны дагуу хувь хүний цалин хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогод ногдох жилийн албан татвараас 84000 төгрөгийг хөнгөлдөг¹. Эдгээрийг тооцож, суутгаж авсны дараа гарт олгох цалингийн дүн гардаг. Энэ аргачлалын дагуу Тэмүүлэнгийн цалингийн орлогоос авах татварыг тооцоолъё.

Зураг 3. Цалингийн орлогод ногдох татварын тооцоолол

Сарын цалингийн хэмжээ = 500,000 төгрөг

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл (10%) = $500,000 \times 10\% = 50,000$ төгрөг
 $500,000 - 50,000 = 450,000$ төгрөг

Орлогын татвар 10% = $450,000 \times 10\% = 45,000$ төгрөг
 Татварын хөнгөлөлт 7,000 төгрөг
 Төлбөл зохих татвар = $45,000 - 7,000 = 38,000$ төгрөг

Авах цалингийн хэмжээ = $500,000 - 50,000 - 38,000 = 412,000$ төгрөг

¹ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, (2006). 24.1 дэх заалт.

3. ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

Улс орны төр, Засгийн газар татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дамжуулан иргэдийн сайн сайхан амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг явуулна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт:

Татвар төлөгчийн олсон орлогыг татвараас чөлөөлөх болон төлбөл зохих татварыг бууруулах үйл ажиллагааг хэлдэг.

Зураг 4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ач холбогдол

Бага татвар төлснөөр гарах зардал багасч, мөнгө хуримтлуулах боломжтой болно.

Татварт өгч байсан мөнгөө хуримтлуулан бизнес эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжтой болно.

Хүн амын эмзэг, ядуу хэсгийн амьдралд тус нэмэр болно.

Хууль тогтоомжийн дагуу иргэнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхдээ:

- ▶ Олсон орлогыг нь татвараас чөлөөлөх;
- ▶ Төлбөл зохих татварыг нь багасгах 2 хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Зураг 5. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

1. Албан татвараас чөлөөлөгдөх орлого

- Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр;
- Даатгалын нөхөн төлбөр;
- Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал;
- Малчин өрх, мал бүхий этгээдийн зөвхөн малын тоо толгойд ногдох орлого;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллаас орсон орлого;
- Хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого;
- Бусад.

2. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт

- Хөдөлмөрийн эрхлэлтийн орлогод ногдох жилийн албан татварт 84,000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал үйлдвэрлэсэн буюу тариалсан Монгол Улсад оршин суугч хувь хүний зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө.
- Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.
- Суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлбөр төлсөн их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг мөн дээр заасан хөнгөлөлтөд хамааруулна.

3. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хөнгөлөлт

- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрын татварыг:
 - нийслэлд 95 хувиар;
 - аймгийн төвд 97 хувиар;
 - сумын төв, тосгонд 98 хувиар.
- Газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрын татварыг:
 - нийслэлд 30 хувиар;
 - аймгийн төвд 70 хувиар;
 - сумын төв, тосгонд 85 хувиар
- Газар тариалангийн зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрын татварыг 95 хувиар тус тус хөнгөлнө.

4. Үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөгдөх хөрөнгө

- Орон сууцыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлнө.

Хувь хүн татварын хөнгөлөлт, материалыг бүрдүүлж, харъяа татварын чөлөөлөлт эдлэхийн тулд шаардагдах албанд өгнө.

Зураг 6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд бүрдүүлэх баримт

1. Татварын тайлангаа ТТ-06/А/ маягт буюу “Хувь хүний албан татвар тодорхойлох тайлан”-гийн маягтаар гаргаж, дараа оны 2-р сарын 15-ны дотор харьяалах татварын албанд тайлагнана.

2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх бичгээр гаргасан хүсэлтийн маягтыг бөглөнө. Үүндээ хөнгөлөлт, чөлөөлөлтийг ямар хэлбэрээр эдлэх тухайгаа тодорхой зааж өгсөн байна.

3. Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд шаардлагатай баримтыг бүрдүүлж хавсаргана. Жишээ нь:

Оюутны сургалтын төлбөрийн татварын хөнгөлөлт эдлэхэд:

1. Тухайн оюутныг төрсөн буюу үрчилсэн хүүхэд гэдгийг нотлох баримт;
2. Оюутны сургуулийн тодорхойлолт;
3. Эцэг, эхээс хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлсөн тухай орлогын баримт;
4. Оюутны “Иргэний үнэмлэх”-ийн баталгаажсан хуулбар.

Орон сууцны барилга барих эсвэл худалдан авахад зарцуулсан ... орлогын чөлөөлөлтийг эдлэхэд:

1. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ”;
- Хувь хүн зээл авсан бол банк болон санхүүгийн байгууллагатай хийсэн зээлийн гэрээ;
2. Хувь хүн өөрийн орлогоор орон сууцаа барьсан бол орон сууцны материалын зардлын баримт, үнэлгээ;
3. Орон сууц барьсан хөрөнгийг албан татвар ногдох орлогод оруулан тооцсоныг нотлох баримт;
4. Өөр этгээдийн өмчилж байсан орон сууц худалдан авсан бол орон сууцаа худалдсан этгээдийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны 2%-ийн албан татвар төлсөн баримтын хуулбар


Эдгээрээс гадна ямарч төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байгаагаас хамаарахгүйгээр дараах бичиг баримтыг заавал бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- ▶ Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр, хуулбарын хамт;
- ▶ Нийгмийн даатгалын дэвтэр, хуулбарын хамт;

- ▶ Ажлын газрын цалингийн тодорхойлолт;
- ▶ Иргэний өөрийн данс, банкны нэр;
- ▶ Татвар төлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхдээ дараах хэлбэрүүдээс аль нэгийг сонгож хөнгөлөлт эдлэх тухай бичгээр гаргасан өргөдөлдөө бичнэ.

Зураг 7. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх хэлбэр



4. ТАТВАРЫН ТАЙЛАН ГАРГАХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ

www.sankhuuginbolovsrol.mn

Хувь хүн орлогын албан татварын тайлангаа хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн

хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор харъяа татварын албанд хүргүүлнэ.

Зураг 8. Татварыг төсөвт төлөх хэлбэр



Байгууллага нь хувь хүнд орлого олгох тухай бүрдээ ногдох татварыг суутган авч төсөвт оруулна. Хувь хүн өөрийн төлөх татварыг хуульд заасан хугацаанд төсөвт төлөх үүрэгтэй. Хувь хүний төлсөн татварыг "Татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэр"-т (иргэдийн ярьж заншсанаар "Цэнхэр дэвтэр") тухай бүр бүртгэн харъяа татварын албаар баталгаажуулна. Энэ

нь банкнаас зээл авах үед тухайн хүний олсон орлогыг тодорхойлох гол баримт болдог. Ялангуяа, хувиараа бизнес хийж байгаа иргэдийн хувьд чухал ач холбогдолтой юм. Тэд ихэвчлэн нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй тул орлого олсон гэдгээ нотлох баримт байдаггүй. Мөн татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэхэд татварын тайлангаа зохих хугацаанд нь гаргаж тушаасан

байхыг шаарддаг. Түүнчлэн хилээр бараа бүтээгдэхүүн, автомашин, хувийн хэрэглээний зүйлс оруулж ирэхэд энэхүү дэвтрийн таних дугаараар гаалийн бүрдүүлэлт хийнэ.

ЗӨВЛӨМЖ:

Та “Цэнхэр дэвтэр” авахын тулд өөрийн амьдарч байгаа дүүргийн татварын албанд иргэний үнэмлэх, 2% зурагтай очиж бүртгүүлээрэй.

Хүснэгт 1. Хувь хүн өөрөө төсөвт төлөх татварын хувь, хугацаа

№	Орлогод ногдох татвар	Татвар %	Төлөх хугацаа
1	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар	2	дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор;
2	Түрээсийн орлогод ногдох албан татвар	10	
3	Үйл ажиллагааны орлогод ногдох албан татвар	10	
4	Өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлогод ногдох албан татвар	10	
5	Хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татвар	10	
6	Хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татвар	10	